



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2023/173/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 08</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.10 № 2/08

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

ИХ БОГДЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Б.БАТ-ӨЛЗИЙ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар 8.9.1-д заасны дагуу Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсөв захирагчаас тавьж олгосон 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянлиг сумын нутагт Бага баян 3 дугаар багийн Тойд хөх толгойт гэх газарт тарималжуулсан заг бүхий талбайд хайлаас, заг, буйлс тариалж хайс хамгаалалт хийж дансанд орлогоор бүртгэсэн ч тухайн нутгийн харьяа байгууллагад хүлээлгэн өгөөгүй байгаа нь тус хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй байгаа нь төсвийн үр ашгийг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилго, 5 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг

005020122

D/2023-A4 Alban toot.doc

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93.2 хувиар үнэлсэн байна.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>50,170,072.59</u>	<u>129,653,620.59</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	3,788,398.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	3,788,398.00
3121	Төгрөг	00.00	3,788,398.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	3,788,398.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,170,072.59	125,865,222.59
351	Түүхий эд материал	45,184,956.00	121,164,106.00
35110	Тусгай зориулалттай материал	45,184,956.00	121,164,106.00
354	Хангамжийн материал	4,985,116.59	4,701,116.59
35410	Бичиг хэргийн материал	495,500.00	513,500.00
35420	Аж ахуйн материал	3,333,216.59	3,783,216.59
35470	Бусад хангамжийн материал	1,156,400.00	404,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>73,375,087.85</u>	<u>94,302,082.05</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	73,375,087.85	94,302,082.05
392	Биет хөрөнгө	73,375,087.85	94,302,082.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,370,117.88	5,370,117.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-402,759.00	-537,012.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	90,635,500.00	146,903,073.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,968,020.92	-59,664,704.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,627,933.34	53,696,641.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,685,927.45	-51,920,981.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,858,990.37	12,558,990.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,060,746.37	-12,104,042.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	529,410.00	529,410.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-529,410.00	-529,410.00
39301	Програм хангамж	495,000.00	495,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-495,000.00	-495,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>123,545,160.44</u>	<u>223,955,702.64</u>
413	Өглөг	144,820.00	00.00
4136	Бусад өглөг	144,820.00	00.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	50,638.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>123,400,340.44</u>	<u>223,955,702.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	123,400,340.44	223,955,702.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	36,953,494.00	36,953,494.00
51101	Өмч: - төрийн	36,953,494.00	36,953,494.00
512	Хуримтлагдсан үр дүн	85,326,728.32	185,882,090.52
51210	Өмнөх үеийн үр дүн	85,326,728.32	85,326,728.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	100,555,362.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,120,118.12	1,120,118.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>123,545,160.44</u>	<u>223,955,702.64</u>

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	442,006,490.00	491,785,372.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,893,412.00	123,707,824.98
120	Нийтлэг татварын бус орлого	43,893,412.00	123,707,824.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	925,340.00	4,878,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	925,340.00	4,878,850.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,640,000.00	57,336,281.98
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	328,072.00	61,492,693.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,113,078.00	368,077,548.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,459,800.00	340,673,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	367,459,800.00	340,673,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,653,278.00	23,615,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,653,278.00	3,615,850.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0	3,788,398.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	3,788,398.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	406,846,326.86	391,230,010.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,846,326.86	391,230,010.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,270,601.58	338,271,423.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,871,600.56	224,283,922.80
210101	Үндсэн цалин	155,721,826.56	171,066,824.80
210102	Нэмэгдэл	39,056,174.00	22,564,549.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,093,600.00	22,385,000.00
210104	Урамшуулал	0	8,267,549.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,079,306.78	27,548,420.78
210201	Тэтгэврийн даатгал	25,805,147.78	19,164,158.70
210202	Тэтгэмжийн даатгал	165,606.00	2,098,718.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	132,485.00	1,747,059.01
210204	Ажилгүйдлийн даатгал	12,695.00	415,041.74
210205	Эрүүл мэндийн даатгал	1,963,373.00	4,123,442.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	330,000.00	0
210302	Түлш, халаалт	330,000.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	30,577,585.21	24,623,325.23
210401	Бичиг хэрэг	1,844,500.00	823,350.00
210402	Тээвэр, шатахуун	23,895,262.60	21,983,943.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,326,600.00	1,111,032.23
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,037,700.00	705,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,473,522.61	0
2105	Нормативт зардал	226,500.00	554,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	226,500.00	554,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,778,700.00	3,785,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	575,000.00
210604	Урсгал засвар	1,778,700.00	3,210,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,423,000.00	1,065,000.00
210702	Дотоод албан томилолт	3,423,000.00	1,065,000.00

**Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,337,405.38	19,182,267.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,812,205.38	18,467,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	59,400.00	50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	87,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	103,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	367,000.00
210807	Газрын төлбөр	0	84,357.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,646,503.65	37,229,287.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,646,503.65	37,109,287.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,575,725.28	52,958,587.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,391,500.00	18,372,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,391,500.00	17,072,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,184,225.28	34,585,887.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,530,947.28	34,585,887.19
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,653,278.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	35,160,163.14	100,555,362.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,224,904.68	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,224,904.68	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	33,935,258.46	100,555,362.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАИЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	399,038,418.00	372,956,398.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	925,340.00	4,878,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	925,340.00	4,878,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	925,340.00	4,878,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	925,340.00	4,878,850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,113,078.00	368,077,548.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,459,800.00	340,673,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	367,459,800.00	340,673,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,653,278.00	23,615,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,653,278.00	3,615,850.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0	3,788,398.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	3,788,398.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	396,553,418.00	368,468,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396,553,418.00	368,468,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,977,692.72	315,509,412.81

**Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,274,084.56	224,387,729.80
210101	Үндсэн цалин	155,850,658.56	174,274,769.80
210102	Нэмэгдэл	39,329,826.00	27,436,811.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,093,600.00	14,408,600.00
210104	Урамшуулал	0	8,267,549.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,340,998.76	27,589,433.78
210201	Тэтгэврийн даатгал	19,039,051.55	19,180,067.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,134,712.97	2,125,779.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,666,606.81	1,743,865.36
210204	Ажилгүйдлийн даатгал	385,878.65	413,925.49
210205	Эрүүл мэндийн даатгал	4,114,748.78	4,125,795.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	330,000.00	0
210302	Түлш, халаалт	330,000.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,885,200.00	12,389,382.23
210401	Бичиг хэрэг	1,123,600.00	847,350.00
210402	Тээвэр, шатахуун	12,434,900.00	9,976,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,111,032.23
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	940,700.00	455,000.00
2105	Нормативт зардал	277,200.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	277,200.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,702,900.00	3,660,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,900.00	0
210604	Урсгал засвар	1,650,000.00	3,660,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,235,000.00	921,000.00
210702	Дотоод албан томилолт	2,235,000.00	921,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,669,309.40	46,441,867.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,043,109.40	45,727,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	59,400.00	50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	87,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	103,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	354,000.00	367,000.00
210807	Газрын төлбөр	0	84,357.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,000.00	120,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	263,000.00	120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,575,725.28	52,958,587.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,391,500.00	18,372,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,391,500.00	17,072,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,184,225.28	34,585,887.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,530,947.28	34,585,887.19
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,653,278.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,485,000.00	4,488,398.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,485,000.00	700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,485,000.00	700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,485,000.00	700,000.00

**Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,485,000.00	700,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,485,000.00	-700,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	3,788,398.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3,788,398.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	48,137,560.65	86,211,172.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	48,137,560.65	86,211,172.77
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	85,326,728.32	123,400,340.44
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	85,326,728.32	123,400,340.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	85,326,728.32	123,400,340.44
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	100,555,362.20	100,555,362.20
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	185,882,090.52	223,955,702.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	341,723,300.00	307,324,912.81	34,398,387.19	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,723,300.00	307,324,912.81	34,398,387.19	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,650,600.00	290,252,212.81	34,398,387.19	89.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,559,900.00	224,387,729.80	28,172,170.20	88.8
210101	Үндсэн цалин	183,917,600.00	174,274,769.80	9,642,830.20	94.8
210102	Нэмэгдэл	44,624,600.00	27,436,811.00	17,187,789.00	61.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,517,700.00	14,408,600.00	109,100.00	99.2
210104	Урамшуулал	9,500,000.00	8,267,549.00	1,232,451.00	87.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,569,900.00	27,589,433.78	3,980,466.22	87.4
210201	Тэтгэврийн даатгал	21,467,600.00	19,180,067.89	2,287,532.11	89.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,600.00	2,125,779.19	399,820.81	84.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,400.00	1,743,865.36	276,534.64	86.3
210204	Ажилгүйдлийн даатгал	505,100.00	413,925.49	91,174.51	81.9
210205	Эрүүл мэндийн даатгал	5,051,200.00	4,125,795.85	925,404.15	81.7
2104	Хангамж, бараа материалын зардал	12,080,800.00	12,078,032.23	2,767.77	100.0
210401	Бичиг хэрэг	536,000.00	536,000.00	-	100.0

**Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	9,977,200.00	9,976,000.00	1,200.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,112,600.00	1,111,032.23	1,567.77	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	455,000.00	455,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,330,000.00	2,330,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,330,000.00	2,330,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	921,900.00	921,000.00	900.00	99.9
210702	Дотоод албан томилолт	921,900.00	921,000.00	900.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,068,100.00	22,826,017.00	2,242,083.00	91.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,162,300.00	22,111,300.00	2,051,000.00	91.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	50,000.00	50,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	124,800.00	87,500.00	37,300.00	70.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	108,000.00	103,860.00	4,140.00	96.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	22,000.00	77,000.00	22.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	367,000.00	367,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	157,000.00	84,357.00	72,643.00	53.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,000.00	120,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,000.00	120,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,072,700.00	17,072,700.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,072,700.00	17,072,700.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,072,700.00	17,072,700.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	341,723,300.00	307,324,912.81	34,398,387.19	89.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	340,673,300.00	306,087,412.81	34,585,887.19	89.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	340,673,300.00	306,087,412.81	34,585,887.19	89.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,050,000.00	1,237,500.00	(187,500.00)	117.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,050,000.00	1,237,500.00	(187,500.00)	117.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	00	100.0

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,000,000.00	23,615,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,000,000.00	23,615,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,000,000.00	22,315,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал		285,850.00
210401	Бичиг хэрэг		285,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,030,000.00
210602	Тавилга		700,000.00
210604	Урсгал засвар		1,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,000,000.00	20,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.00	20,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1300000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,000,000.00	23615850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	23,615,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,615,850.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Тусгай хамгаалалттай газар нутгийн экологийн тэнцвэрт байдал унаган төрхийг хадгалах зорилгоор судлан шинжлэх, хойд үедээ өвлүүлэх, байгаль орчныг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, байгалийн баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад стандартыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

БОАЖЯ-ны ХШҮДАГ нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021-2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БОАЖЯ-ны дотоод аудитын 2018.07.20-ны өдрийн 03-р тогтоолын заалт, зөвлөмжийг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.03.03-ны өдрийн А/58 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад үндэслэн байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2018.07.20-ны өдрийн А/43 тоот тушаалаар батлагдсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 223,955.7 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 100,410.5 мянган төгрөгөөр буюу 81.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	3,788.4	3,788.4
Авлага	-	-	-
Бараа материал	50,170.1	125,865.2	75,695.2
Үндсэн хөрөнгө	161,517.0	219,553.2	58,036.3
Хуримтлагдсан элэгдэл	(88,141.9)	(125,251.2)	(37,109.3)
Нийт хөрөнгө	123,545.2	223,955.7	100,410.5
Өр төлбөр	144.8	-	(144.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	123,400.3	223,955.7	100,555.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	123,545.2	223,955.7	100,410.5

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,788.4 мянган төгрөг болж нэмэгдсэн нь тайлант онд ахмадын сан шинээр байгуулж мөнгө төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 125,865.2 мянган төгрөг болж өмнөх оноос 75,695.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн болон төслийн хөрөнгөөр худалдан авсан 51,577.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 61,492.7 мянга бүгд 113070.3 мянган төгрөгийн орлого авч 35,996.0 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулж 1379.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасантай холбоотой байна.

Үүнд БОАЖСайдын 2022 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан “Цөлөрхөг хээрийн бүсэд ховор ургамал тарималжуулах хайс хамгаалалт хийх” 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч Баянлиг сумын нутагт хайлаас, заг, буйлс тариалж хайс хамгаалалт хийж 16,500.0 мянга, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн санхүүжилтээр нийт ажилтан, албан хаагчдад 59,801.9 мянган төгрөгийн хувцас хэрэгслийг тусгай зориулалтын дансанд бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 94,302.1 мянган төгрөг болж 20927.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 700.0 мянга, 2019 онд хүлээн авсан Mitsubishi L-200 автомашин 56,267.6 мянга, БОАЖЯамнаас 1,068.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Өр төлбөр данс нь оны эхэнд 144.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 223,955.7 мянган төгрөг болж 100,555.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 100,555.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 564,205.5 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,050.0 мянга нийт зарлагыг 565,255.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 214,842.2 мянган төгрөгөөр бууруулж 350,143.3 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 341,644.8 мянган төгрөг болгож 8,498.5 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71405 хөтөлбөрийн 80101, 80802, 81101, 81703 арга хэмжээг санхүүжүүлэхээр 341,644.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 340,594.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,050.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 340,673.3 мянган санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,237.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 34,585.9 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 307,324.9 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 34,398.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71405 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	341,723.3	307,324.9	34,398.4	90.5
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	300,488.3	268,140.9	32,347.4	89.2
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	17,072.7	17,072.7	0	100
4	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	15,753.2	15,753.2		100
5	81703 Ургамал хамгаалал	8,409.1	6,358.1	2051.0	75.6
	Нийт дүн	341,723.3	307,324.9	34,398.4	90.5

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100032055405 тоот дансанд 23,615.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

		/мянган төгрөгөөр/
д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	БОАЖЯ (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт)	20,000.0
2	Давсан орлого (Сангийн сайдын 243 дугаар тушаал)	3,615.8
	Нийт орлогын дүн	23,615.8

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд БОАЖСайдын 2022 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан “Цөлөрхөг хээрийн бүсэд ховор ургамал тарималжуулах хайс хамгаалалт хийх” 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, Сангийн сайдын 243 дугаар тушаалаар давсан орлогоос 3,615.8 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлж зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 21-ны өдрийн 170 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын түр орлон гүйцэтгэгч Б.Бат-Өлзий, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Гантөмөр нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үрдүнгийн тайлангийн 406,846.3 мянган төгрөгөөс 4,068.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 2,847.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 137 мэдээлэл хугацаандаа оруулж 12 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 25499.6 мянга, зарлагын 2 мөнгөн гүйлгээний 49,607.6 мянган хугацаа хоцроосон байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	87	9	
	Нийт	27	151	137	12	2

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 847.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 559.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 288.3 мянган төгрөгийн зөрчилд анхан шатны баримтыг үнэн зөв хөтлөх, хяналтыг сайжруулах, шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийн хуулийн хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлж байх 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн бөгөөд Их богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2022.05.30-ны өдрийн 72 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	283.4	2	283.4	100
Нийт дүн	2	283.4	2	283.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсөв захирагчаас тавьж олгосон санхүүжилтээр Баянлиг сумын нутагт Багабаян 3 дугаар багийн Тойд хөх толгойт гэх газарт тарималжуулсан заг бүхий талбайд модон шон 200 ширхэг, Төмөр шон 200 ширхэг, Хайлаас мод 300 ширхэг Заг 100ширхэг, Буйлс 400 ширхэг Шар хуайс мод 300 ширхэг нийт 1000 ширхэг тарьц суулгаж 375:80 хэмжээтэй нийт 910 метрийн торон хайс хийж байгууллагын бараа материалын дансанд орлогоор бүртгэж тухайн нутгийн харьяа байгууллагад хүлээлгэн өгөөгүй байгаа нь тус хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй байгаа нь төсвийн үр ашгийг алдагдуулж байна. Цаашид энэ мэт зардлыг санхүүжүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах байдлыг таслан зогсоох зайлшгүй шаардлагаар хамгаалалт хийх тохиолдолд чанартай насжилт өндөр материалаар хийж орон нутгийн үндсэн хөрөнгөнд бүртгүүлэн хүлээлгэн өгч төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар анхаарч ажилласан эсэх талаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,429.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7,429.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залрууллаа.

1. Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дэргэдэх ахмадын зөвлөлийг 2022 оны 12 сарын 23 өдөр байгуулж 0372001027 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна. Тухайн байгууллага нь байгууллагын даргын 2022.12.21-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар 2022 онд батлагдсан нийт цалингийн сангийн 1.5 хувьтай тэнцэх хэмжээний 3,788.4 мянган төгрөгийг 2022.12.23-ны өдөр Их богдын БЦГХЗ-ны ахмадын сангийн 100030013502 тоот дансанд шилжүүлсэн бөгөөд тухайн дансанд үлдэгдлээр байхад санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "Үнэн зөв байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 1050.0 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэлээр 4878.8 мянган төгрөгийн орлого орж давсан орлого болох 3,615.8 мянган төгрөгийг зарцуулах эрхийг Сангийн сайдын 2022.12.07-ны өдрийн 243 дугаар тушаалаар олгож нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан, мөн албан бланкын дутааснаас нөхөн төлүүлсэн 25.5 мянган төгрөгийг тус тус төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилт хийгээгүй орлого, зарлагаар, тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3 "Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Дээрх алдааг санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр 3,788.4 мянга, давсан орлого болох 3,615.8 мянга, албан бланкны 25.5 мянган төгрөгийг тус тус төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого, зарлагаас хасаж тохируулан нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлангаар залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 765.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 335.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 430.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчид томилолтоор ажилласан хугацаанд Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн "Албан томилолтын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалаар хоолны зардал олгосон байхад давхардуулан дээрх хугацаанд хоолны нөхөн олговрын 335.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалын 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад давхардуулан олгосон 335.0 мянган төгрөгийн хоолны зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 0075 дугаар шийдвэрийн дагуу Их богд БЦГХЗ-ны дарга байсан Т.Ганболдын 2021.01.22-ны өдрөөс 2022.02.22 -ны өдрийг хүртэлх НДШ-д 430.7 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан 430.7 мянган төгрөгийг хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх төсвийг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгөв.

5.3. Зөвлөмж

1. Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 137 мэдээлэл хугацаандаа оруулж 12 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 25,499.6 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, зарлагын 2 мөнгөн гүйлгээний 49,607.6 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг үнэн зөв мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ахмадын сангийн үлдэгдлийг дансанд үлдэгдлээр тусгаагүй байна	1	3,788.4			1	3,788.4	1	3,788.4				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагаанаас давсан орлого 3,615.8 мянга, албан бланкын нөхөн төлүүлсэн 25.5 мянган төгрөгийн орлогыг тохируулах бичилт хийгээгүй байна	1	3,641.3			1	3,641.3	1	3,641.3				
Дүн	1	7,429,7			1	7,429,7	1	7,429,7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томилолтын хоолны зардлыг хоолны зардлын нөхөн олговортой давхардуулан олгосон байна.	1	335.0	1	335.0								
Их богд БЦГХЗ-ны дарга байсан Т.Ганболдын 2021.01.22-ны өдрөөс 2022.02.22 -ны өдрийг хүртэлх хугацааны 430,7 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлсөн байна	1	430.7			1	430.7						
Нийт дүн	2	765.7	1	335.0	1	430.7						

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.	1	0					1	0
Дүн	1	0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0			0	0	1	0

ooOoo